



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 26 өдөр

Дугаар №139

Мандалговь

Г  
Дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6 дугаар зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах дэд хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дэд хорооны дарга:

Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Гишүүдэд:

Б.Мөнхжаргал (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

Г.Хишигдаваа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)

Д.Чандмань (Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны тэргүүн)

Ш.Оюун (Монголын тогооч нарын холбооны тэргүүн)

С.Өлзийсайхан (Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны гүйцэтгэх захирал)

Д.Ганчимэг (Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимын менежер)

Нарийн бичгийн дарга:

Ж.Мөнхбаяр (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)

Хоёр. Төсөл сонгон шалгаруулалтыг журмын дагуу үүрэг хариуцлагаа өндөр ухамсарлан хууль, дүрэм журам, зааврыг чанд мөрдөн зохион байгуулах шийдвэр, эрэмбэлсэн жагсаалтыг аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг дэд хороо (Н.Эрдэнэ-Очир)-д даалгасугай.

Гурав. Уг захирамж гарсантай холбогдуулан 2019 оны А/199 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О. БАТ-ЭРДЭНЭ

482010394